Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан өөрийн үйл ажиллагааны орлого байна. Энэ нь Ковид-19 цар тахлаас шалтгаалж амрагч хүүхдийн тоо эрс цөөрч өмнөх оноос 2,960,215.2 мянган төгрөгөөр өөрийн орлого буурсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 999,478.6 мянган төгрөгөөр буюу 18.4 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс амрагч хүүхдүүдийн тоо буурснаас материаллаг буурах өөрчлөлт гарсан хоолны зардал 778,276.5 мянга, тээвэр шатахууны зардал 135,810.4 мянга, зардлууд байгаа бол гэрээт багш нар аваагүй боловч цалин нэмэгдэл, урамшуулалын зардал өмнөх оноос 114,588.0 мянган төгрөгөөр өссөн өөрчлөлттэй байна. Цалингийн зардал өссөн нь ажиллагсад төлөвлөгдөөгүй, улирлын үр дүнгийн урамшуулалыг нөхөн олгосноос шалтгаалжээ.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 5,316,043.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 5,316,043.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг хэвээр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх хүүхдийн хөгжил хамгааллын 1 хөтөлбөрийг санхүүжүүлэхээр 5,316,403.7 мянган төгрөгийн төсөв баталснаас 2,436,145.7 мянган төгрөгийг улсын төсвөөс, 2,879,897.0 мянган төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,436,145.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 1,447,799.1 мянган төгрөг, нийт 3,883,944.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 3,887,090.3 мянган төгрөгийг зарцуулж 10,304.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,887,090.3 мянган төгрөг буюу 73.1 хувьтай байгаа нь хоол хүнсний зардлыг 379,166.0 мянга, цалин, нэмэгдэл, урамшууллын зардлыг 481,512.9 мянга, нормын хувцас, зөөлөн эдлэл, эм бэлдмэлийн зардал 34,544.6 мянга, хангамж, бараа материалын зардал 49,928.3 мянга, эд хогшил худалдан авах зардал 153,715.5 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 155,935.5 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 29,154.0 мянган төгрөгөөр тус тус батлагдсан төсвөөс дутуу зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь цар тахлаас шалтгаалан амрагч хүүхдүүдийн тоо буурсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 231 мэдээллээс хугацаандаа оруулсан 146 мэдээлэл, 2,153,390.9 мянган төгрөгийн 85 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна. Үүнд: Жилийн эцсийн тайлан, өмнөх оны гүйцэтгэл, батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт, хэмнэлт 1-12 сар, тайлбарлаагүй, цалингаас бусад 5 саяас дээш гүйлгээ, санхүүжилтийн орлогын 29 гүйлгээ, зарлагын нийгмийн даатгалын шимтгэл, хүн амын орлогын албан татвар, мах, сүү, ногоо, хүнсний бүтээгдэхүүн, бусад бараа худалдан авсан 51 гүйлгээ.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 38,404.0 мянган төгрөгийн зөрчилд 8,142.0 мянган төгрөгийн төлбөрийн 3 акт, 30,262.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлагаас 5,818.6 мянган төгрөгийн акт, 30,262.0 мянган төгрөгийн албан шаардлага биелүүлээгүй байна. Аудитаар өгсөн 4,030.8 мянган төгрөгийн 3 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Акт	3	8,142.0	2	2,323.4	1	5,818.6	28.5
Албан шаардлага	1	30,262.0	0	0	1	30,262.0	0
Зөвлөмж	2	4,030.4	2	4,030.4	0	0	100
Нийт дүн		42,434.4		6,353.8		36,080.6	

Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын Захирал, ерөнхий нягтлан бодогч нар ажлаас чөлөөгдсөн тул барагдуулаагүй 5,818.6 мянган төгрөгийн төлбөрийн акт, 30,262.0 мянган төгрөгийн албан шаардлагад Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д заасны дагуу холбогдох албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах боломжгүй болсон ба шинээр томилогдсон удирдагуудад дахин албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2,221,551.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 28,464.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 7,734.0 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 2,189,471.5 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, 27,462.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 6 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын эзэмшлийн гэрчилгээтэй 137,708.2 мянган төгрөгөөр үнэлж нягтлан бодох бүртгэлд тусгасан 11,690.0 мянган м2 газрын эзэмших эрхэд 18,361.1 мянган төгрөгийн элэгдэл байгуулсаныг,
2. Иргэнд төлөх ажлын хөлсний төлбөрийг нягтлан бодогч, нярав нарын нэрээр 3,500.0 мянган төгрөгийн цалин тооцоолон гаргаж зардалд тайлагнасныг,
3. Ажлаас чөлөөлөгдсөн 2 иргэнтэй холбоотой 3,397.4 мянган төгрөгийн авлага суутгасныг бүртгээгүй,
4. Ажлаас чөлөөлөгдсөн 3 иргэн тус бүрд 2 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг нягтлан бодогч, нярав нарын нэрээр 3,206.4 мянган төгрөгийн цалин тооцоолон гаргаж зардалд тайлагнасныг залруулсан.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 2,165,624.9 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 7,734.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 2,157,890.9 мянган төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Ажиллагсад Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоосон Засгийн газрын тогтоолын цалингийн шатлалаас илүү олгосон, захирлын тушаалаар ноогдуулсан сахилгын шийтгэлийг хэрэгжүүлээгүй, нэмэгдэл цалин илүү олгосон нийт 7,734.0 мянган төгрөгийн зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” заалттай нийцэхгүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

2. Өмнөх аудитаар тогтоосон 5,818.6 мянган төгрөгийн төлбөрийн акт, 30,262.0 мянган төгрөгийн авлага барагдуулах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

3. Ажиллагсдын цалингийн тооцооны хүснэгтээр 2020 онд гарт олгох цалин 1,250,928.5 мянган төгрөг тодорхойлогдсон боловч төлбөрийн хүсэлтээр байгууллагын харилцах данснаас 1,265,237.5 мянган төгрөг шилжүүлж, 14,309.0 мянган төгрөгийн илүү зөрүүгээр ажиллагсадтай холбоотой 9,809.0 мянган төгрөгийн тооцоог барагдуулж, 4,500.0

мянган төгрөгийн гэрээт ажлын хөлсийг цалингийн зардлаар тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.4-т “үнэн зөв байх”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-т “Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 16.5.6- “дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэсэн заалтуудтай нийцэхгүй, тохиолдсон байх, үнэн зөв байх, эрх үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

4. Төрийн байгууллагын газар эзэмших эрхийн 0178537 дугаартай 15 жилийн хугацаатай гэрчилгээтэй 12,250,000 м2 газраас 2010 оноос эхлэн нэр бүхий 24 иргэн, аж ахуйн нэгжүүдэд газар эзэмших эрхийн гэрчилгээ олгосон Нийслэл, дүүргийн Засаг дарга нарын хууль бус захирамжуудыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Амарсайхан 2019 оны 9 дүгээр сарын 5-ны өдрийн А/902 дугаартай захирамжаар хүчингүй болгосон, эзэмшлийн гэрчилгээг шинэчлэн олгох асуудлыг шийдвэрлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Асуудлыг шийдвэрлэх талаар Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны дарга А.Энхманлайд Албан шаардлага хүргүүлэв

5. Шилэн дансанд байршуулбал зохих 231 мэдээллээс 2,153,390.9 мянган төгрөгийн 85 мэдээллийг байршуулаагүй Үүнд: Жилийн эцсийн тайлан, өмнөх оны гүйцэтгэл, батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт, хэмнэлт 1-12 сар, тайлбарлаагүй, цалингаас бусад 5 саяас дээш гүйлгээ, санхүүжилтийн орлогын 29 гүйлгээ, зарлагын нийгмийн даатгалын шимтгэл, хүн амын орлогын албан татвар, мах, сүү, ногоо, хүнсний бүтээгдэхүүн, бусад бараа худалдан авсан 51 гүйлгээ байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 27,462.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 5 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Ажлаас үндэслэлгүй чөлөөлсөн байж болзошгүй ажиллагсдад олгосон 2 сарын цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийн асуудлуудыг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Шатахуун, бензин олгосон шаардах хуудасгүй, хүнсний материалын тооцоот цэс маягтаар хоол идсэн нийт хүний тоог амрагч хүүхэд, ажилчид, өдрийн амрагч том хүн гэж ангилаагүй, нэг орцоор тооцоо бодсон, нормын сүү олгосон баримтуудад хүний нэр, гарын үсэггүй 352.0 мянган төгрөг, кассын баримтанд 39 иргэнд олгосон 110.0 мянган төгрөгийн сугалааны дугаартай и-баримттай дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв байх батламж мэдээдлийг хангахгүй байна.

1.2. Эрсдэл:

Анхан шатны баримтын бүрдэл хангаагүй ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч нягтлан бодох бүртгэлд тусгаагдах, төсвийн хөрөнгийг үргүй зарцуулах

1.3. Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтын бүрдэл, хүчин төгөлдөр байдлыг хангах

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Хойшид баримтын бүрдлийг хангаж зөвлөмжийн хэрэгжүүлж ажиллана.

2. Дотоод хяналттай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Тайланд жилд хөрөнгө, санхүүгийн дотоод хяналтыг зохион байгуулаагүй, цалин нэмэгдэл, урамшууллын тооцоолол, баримтын бүрдэлийг хянаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн “Нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналт” 19.1. “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно” гэсэн заалтуудтай нийцэхгүй, үнэн зөв байх батламж мэдээдлийг хангахгүй байна.

2.2. Эрсдэл:

Хөрөнгө үрэгдэх, бусдад ашиглагдах, төсвийн хөрөнгө үргүй зарцуулагдах

2.3. Өгсөн зөвлөмж:

Дотоод хяналтыг сайжруулж, зөрчил дутагдалтай асуудалд зөвлөмж, албан шаардлага өгч гүйцэтгэлийг шалгаж баримтжуулан баталгаажуулж байх,

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Дотоод хяналтыг сайжруулж, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3. Байгууллагын өмчийн орон сууцанд гаднын иргэд амьдарч байгаатай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Байгууллагын өмчийн орон сууцанд тэтгэвэрт гарсан 4 хүн болон хамааралгүй 8 айл өрх амьдарч байгаа нь байгууллагын дотоод журмын “хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа ажилчдыг орон сууцаар хангах” гэсэн заалттай нийцэхгүй байна

3.2. Эрсдэл:

Улаанбаатар хотоос алслагдмал байрлалтай тул байгууллагын орон сууцанд амьдрах хүсэлт гаргасан одоо ажиллаж байгаа ажиллагсад орон сууцаар хангагдахгүй байх

3.3. Өгсөн зөвлөмж:

Гаднын иргэдээс байрыг чөлөөлөх, одоо ажиллаж байгаа өөрийн ажиллагсдыг орон сууцаар хангах

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Гаднын иргэдээс байрыг чөлөөлж зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

4. Авлагатай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Авлага барагдуулах, үлдэгдлийг баталгаажуулах ажил хангалтгүй, авлагын үлдэгдэл 171,614.4 мянган төгрөг болж нэмэгдсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", гэсэн заалтуудтай нийцэхгүй, оршин байх, эрх үүрэг гэсэн батламж мэдээдлийг хангахгүй байна.

4.2. Эрсдэл:

Төвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах, авлага найдваргүй болох

4.3. Өгсөн зөвлөмж:

Авлага бууруулах ажлыг эрчимжүүлэх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны авлага, өглөг ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах" 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллах.

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

5. Урьдчилж төлсөн тооцоотой холбоотой асуудал

5.1. Илрүүлэлт:

Урьдчилж төлсөн тооцооны авлага барагдуулах ажил удаашралтай, 27,000.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны авлага, өглөг ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллах" гэсэн заалтуудтай нийцэхгүй, оршин байх, эрх үүрэг гэсэн батламж мэдээдлийг хангахгүй байна.

5.2. Эрсдэл:

Төвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах, авлага найдваргүй болох

5.3. Өгсөн зөвлөмж:

Авлага бууруулах ажлыг эрчимжүүлэх.

5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

6.Зардлын данстай холбоотой асуудал

6.1. Илрүүлэлт:

Ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан цогцолбор хэвийн ажиллаагүй, үйл ажиллагааны орлого буурсан, гэрээт багш нарыг төлөвлөсөн хэмжээнд авч ажиллуулаагүй зэрэг нөхцөлд төлөвлөгдөөгүй, улирлын урамшуулалт цалинг зөрчилтэй шийдвэрүүдээр нийт ажиллагсдад нөхөн олгосон зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1."төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" заалттай нийцэхгүй байна.

6.2. Эрсдэл:

Төсвийн хөрөнгө зориулалтын бус, үргүй зарцуулагдах

6.3. Өгсөн зөвлөмж:

Төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах, зөрчлийг дахин давтахгүй байх

6.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Олон Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			САГ-2021/167/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолбор		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Ажиллагсад Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоосон Засгийн газрын тогтоолын цалингийн шатлалаас илүү олгосон, захирлын тушаалаар ноогдуулсан сахилгын шийтгэлийг хэрэгжүүлээгүй, нэмэгдэл цалин илүү олгосон	7,734.0	Төлбөрийн акт	Ерөнхий захирал, Ерөнхий нягтлан бодогч	Б.Отгонбат М.Баярмаа
2	Ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан цогцолбор хэвийн ажиллаагүй, үйл ажиллагааны орлого буурсан, гэрээт багш нарыг төлөвлөсөн хэмжээнд авч ажиллуулаагүй зэрэг нөхцөлд төлөвлөгдөөгүй, улирлын урамшуулалт цалинг зөрчилтэй шийдвэрүүдээр нийт ажиллагсдад нөхөн олгосон	0	Зөвлөмж	Ерөнхий захирал, Ерөнхий нягтлан бодогч	Б.Отгонбат М.Баярмаа
3	Өмнөх аудитаар 5,818.6 мянган төгрөгийн төлбөрийн акт, 30,262.0 мянган төгрөгийн авлага барагдуулах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй.	0	Албан шаардлага	Ерөнхий захирал, Ерөнхий нягтлан бодогч	Б.Отгонбат М.Баярмаа
4	Ажиллагсдын цалингийн тооцооны хүснэгтээр 2020 онд гарт олгох цалин 1,250,928.5 мянган төгрөг тодорхойлогдсон боловч төлбөрийн хүсэлтээр байгууллагын харилцах данснаас 1,265,237.5 мянган төгрөг шилжүүлж 14,309.0 мянган төгрөгийн илүү шилжүүлэг хийж, ажиллагсадтай холбоотой 9,809.0 мянган төгрөгийн тооцоог барагдуулж, 4,500.0 мянган төгрөгийн гэрээт ажлын хөлсийг цалингийн зардлаар тайлагнасан.	4,500.0	Албан шаардлага	Ерөнхий захирал, Ерөнхий нягтлан бодогч	Б.Отгонбат М.Баярмаа

5	Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын газраас 2010 оноос эхлэн нэр бүхий 24 иргэн, аж ахуйн нэгжүүдэд газар эзэмших эрхийн гэрчилгээ олгосон Нийслэл, дүүргийн Засаг дарга нарын хууль бус захирамжуудыг 2019 онд хүчингүй болгосон боловч газрын эзэмшлийн гэрчилгээг шинэчлэн олгох асуудлыг шийдвэрлээгүй.	0	Албан шаардлага	Нийслэлийн Газар зохион байгуулалт-ын албаны дарга	А.Энхманлай
6	Шатахуун, бензин олгосон шаардах хуудас, хүнсний материалын тооцоот цэс маягтаар хоол идсэн нийт хүний тоог амрагч хүүхэд, ажилчид, өдрийн амрагч том хүн гэж ангилаагүй, нэг орцоор тооцоо бодсон, нормын сүү олгосон баримтуудад хүний нэр, гарын үсэггүй 352.0 мянган төгрөг,кассын баримтанд 39 иргэнд олгосон 110.0 мянган төгрөгийн сугалааны дугаартай и-баримттай	462.0	Зөвлөмж	Ерөнхий захирал, Ерөнхий нягтлан бодогч	Б.Отгонбат М.Баярмаа
7	Тайланд жилд хөрөнгө, санхүүгийн дотоод хяналтыг зохион байгуулаагүй, цалин нэмэгдэл, урамшууллын тооцоолол, баримтын бүрдэл, баримтын хүчин төгөлдөр байдлыг хянаагүй .	0	Зөвлөмж	Ерөнхий захирал, Ерөнхий нягтлан бодогч	Б.Отгонбат М.Баярмаа
8	Шилэн дансанд байршуулбал зохих 231 мэдээллээс 85 мэдээллийг байршуулаагүй Үүнд: Жилийн эцсийн тайлан, өмнөх оны гүйцэтгэл, батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт, хэмнэлт 1-12 сар, тайлбарлаагүй, цалингаас бусад 5 саяас дээш гүйлгээ, санхүүжилтийн орлогын 29 гүйлгээ, зарлагын нийгмийн даатгалын шимтгэл, хүн амын орлогын албан татвар, мах, сүү, ногоо, хүнсний бүтээгдхүүн, бусад бараа худалдан авсан 51 гүйлгээ	2,153,390.9	Албан шаардлага	Ерөнхий захирал, Ерөнхий нягтлан бодогч	Б.Отгонбат М.Баярмаа
9	Байгууллагын өмчийн орон сууцанд тэтгэвэрт гарсан 4 хүн болон хамааралгүй 8 айл өрх амьдарч байна.	0	Зөвлөмж	Ерөнхий захирал, Ерөнхий нягтлан бодогч	Б.Отгонбат М.Баярмаа
10	Урьдчилж төлсөн тооцоо дансанд үлдэгдэлтэй, барилгын засварын ажил гүйцэтгэхээр Эй Би Жи ХХК-ийн 2015 онд үүссэн урьдчилгаа барагдаагүй	27,000.0	Зөвлөмж	Ерөнхий захирал, Ерөнхий нягтлан бодогч	Б.Отгонбат М.Баярмаа
ДҮН		2,193,086.9			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2021 оны 02 дугаар сарын 25

№ 47/А0170068

Улаанбаатар хот

С.т.г. 2021/167/СТА ТЦЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Засгийн газрын тогтоолоор баталсан Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээг шинэчлэн тогтоосон тогтоолын шатлалыг ахиулан илүү олгосон, захирлын тушаалаар ноогдуулсан сахилгын шийтгэлийг хэрэгжүүлээгүй, нэмэгдэл цалинг 4 албан хаагчид 1,042,726 төгрөг, ажиллагсадд төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, ур чадварын нэмэгдэл, зэрэг дэвийн нэмэгдэл цалинг үндсэн цалингаас тооцоолж илүү олгосон 6,691,274 төгрөг нийт 7,734,000 төгрөгийн зөрчил гаргасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" заалттай нийцэхгүй, үнэн зөв байх Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Ажилтнуудад илүү олгосон цалин, нэмэгдлийн нийт 7,734,000 төгрөгийг (долоон сая долоон зуун гучин дөрвөн мянга) төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын Ерөнхий захирал Б.Отгонбат, Ерөнхий нягтлан бодогч М.Баярмаа нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР
"БЭСТ ФОРТУНА АУДИТ" ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Э.БУГҮНҮТЭЙ

Ж.ОЮУНЦЭЦЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264730

\\10.10.10\Bichig_Khereg\Aka\2021\0225auditin 2-R Газар47.Docx

001090536



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 168/А0170068

Улаанбаатар хот

СБГ-2021/767/СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Шилэн дансанд байршуулбал зохих 231 мэдээллээс 2,497,418.5 мянган төгрөгийн 85 мэдээллийг байршуулаагүй байна. Үүнд:

Жилийн эцсийн тайлан, өмнөх оны гүйцэтгэл, батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт, хэмнэлт 1-12 сар, тайлбарлаагүй, цалингаас бусад 5 саяас дээш гүйлгээ, 1,3,5,6,7,8,9,10,11 саруудын санхүүжилтийн орлогын 29 гүйлгээ, зарлагын 1,2,3,5,6,7,9,10,11,12 саруудын нийгмийн даатгалын шимтгэл, хүн амын орлогын албан татвар, мах, сүү, ногоо, хүнсний бүтээгдэхүүн, бусад бараа худалдан авсан нийт 51 гүйлгээ.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор”, 6.1.6-д “төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр”, 6.4.4-д “таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Байгууллагын шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих мэдээллийг хугацаанд нь, бүрэн байршуулж хэвших, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 6 дүгээр сарын 10-ны дотор Үндэсний Аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын Ерөнхий захирал Б.Отгонбат, ерөнхий нягтлан бодогч М.Баярмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР
“БЭЭСТ ФОРТУНА АУДИТ” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Э.БҮГҮНҮТЭЙ

Ж.ОЮУНЦЭЦЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 169/A0170068

Улаанбаатар хот

САГ-0021/167/СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх аудитаар өгсөн 5,818.6 мянган төгрөгийн төлбөрийн акт, 30,262.0 мянган төгрөгийн авлага барагдуулах албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, актын биелэлтийг бүрэн хангаж 2021 оны 6 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын Ерөнхий захирал Б.Отгонбат, Ерөнхий нягтлан бодогч М.Баярмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТОР

Э.БҮГҮНҮТЭЙ

"БЭСТ ФОРТУНА АУДИТ" ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ж.ОЮУНЦЭЦЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 05

№ 170/А0170068

Улаанбаатар хот

С.Аг. 0021/167/СТА-ТЧЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын газрын эзэмшлийн гэрчилгээг шинэчлэн олгох асуудлыг шийдвэрлээгүй, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2019 оны 9 дүгээр сарын 5-ны өдрийн А/902 дугаартай захирамжийн хэрэгжилтийг хангахгүй байна.

Энэ нь Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-д "Хурал, Засаг даргаас хууль тогтоомжид заасан эрх хэмжээнийхээ хүрээнд гаргасан шийдвэр тухайн нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр дагаж мөрдөгдөх бөгөөд түүнийг холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэд заавал биелүүлнэ" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2019 оны 9 дүгээр сарын 5-ны өдрийн А/902 дугаартай захирамжийг хэрэгжүүлж Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын Газар эзэмших эрхийн гэрчилгээг шинэчлэн олгохгүй байгаа асуудлыг шийдвэрлэн, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны дарга А.Энхманлай, Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын Ерөнхий захирал Б.Отгонбат нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТОР
"БЭСТ ФОРТУНА АУДИТ" ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Э.БҮГҮНҮТЭЙ

Ж.ОЮУНЦЭЦЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2021\0225auditin 2-R Gazar 150.Docx



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 171/А070068

Улаанбаатар хот

САН-2021/167/СТА-ТЦЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ажиллагсдын цалингийн тооцооны хүснэгтээр 2020 онд гарт олгох цалин 1,250,928.5 мянган төгрөг тодорхойлогдсон боловч төлбөрийн хүсэлтээр байгууллагын харилцах данснаас 1,265,237.5 мянган төгрөг шилжүүлж, 14,309.0 мянган төгрөгийн илүү зөрүүгээр ажиллагсадтай холбоотой 9,809.0 мянган төгрөгийн тооцоог барагдуулж, 4,500.0 мянган төгрөгийн гэрээт ажлын хөлсийг цалингийн зардлаар тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.4-т "үнэн зөв байх", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-т "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", санхүүгийн тайлангийн "тохиолдсон байх", "үнэн зөв байх", "эрх үүрэг" гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн шууд захирагч нь төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, дотоод хяналтыг сайжруулж, зөрчлийг арилган, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын Ерөнхий захирал Б.Отгонбат, ерөнхий нягтлан бодогч М.Баярмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР
"БЭСТ ФОРТУНА АУДИТ" ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Э.БҮГҮНҮТЭЙ

Ж.ОЮУНЦЭЦЭГ

ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing, consisting of 32 lines.

